




2024 10-р сар

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААНЫ АЛБА

УЛСЫН ТӨСВИЙН НИЙТ ЗАРДАЛ 19.8 ИХ НАЯД ТӨГРӨГТ ХҮРЧ ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕЭС 34 ХУВИАР НЭМЭГДЛЭЭ.

- Төсвийн зардлын 79 хувийг урсгал зардал, 20 хувийг хөрөнгийн зардал, 1.5 хувийг цэвэр зээл бүрдүүлж байна. Үүнд, татаас ба шилжүүлэг нийт урсгал зардлын 54 хувийг дангаар эзлэж байна. Харин төсвийн нийт орлого 22.8 их наядад хүрч өмнөх жилээс 25.9 хувиар өссөнөөр төсвийн тэнцэл 1.5 их наяд төгрөгийн ашигтай гарлаа.
- Төсвийн зардал энэ оны эцэст 30.5 их наяд хүрэх хүлээлттэй байгаа ба энэ нь өмнөх оноос 8 их наядаар нэмэгдэж байгаа үзүүлэлт юм. Төсвийн зардлын өөрчлөлттэй холбоотойгоор цалин, тэтгэврийн хэмжээ нэмэгдэж иргэдийн хэрэглээний зардлыг өсгөх нөлөө үзүүлж байгаа ба энэ нь дотоод эрэлтийг эрчимжүүлснээр инфляцыг эргэн өдөөх шалтгаан болж байна.

ЖИЛИЙН ИНФЛЯЦЫН ТҮВШИН 3-Р УЛИРЛЫН БАЙДЛААР 6.7 ХУВЬТАЙ ГАРЛАА.

- Инфляцын өсөлтийн 32.6 хувь нь хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнийн өсөлтөөс, 14 хувь нь боловсролын үйлчилгээний өсөлтөөс, 10 хувь нь орон сууц, цахилгаан, түлшний үнийн өсөлтөөс шалтгаалж байна. Мөн импортын барааны үнийн өсөлт нийт инфляцын өсөлтийн 2.2 хувийг бүрдүүлээ. Хэрэглээний зардал нэмэгдсэнтэй холбоотойгоор импортын өсөлт 9-р сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад 27 хувиар өссөн ба энэ нь экспортын өсөлтөөс даруй 6.4 дахин их үзүүлэлт юм.
- Засгийн газраас эрчим хүчний салбарын санхүү, эдийн засгийн бие даасан байдлыг хангах зорилгоор эрчим хүчний тарифын шинэчлэлийг хэрэгжүүлэхээ зарласан ба 11 сарын 1-с хэрэгжинэ. Үүнд цахилгааны тарифыг 29.6 хувиар, дулааны тарифыг 42.6-85.9 хувиар нэмэгдүүлэхээр болсон байна. Эрчим хүчний тарифын нэмэлт зардал нь иргэдийн суурь хэрэглээний зардлыг нэмэгдүүлэх нөлөөг үзүүлж байгаа тул инфляцыг тодорхой хэмжээнд өсгөх хүлээлттэй байна.

НҮҮРСНИЙ ЭКСПОРТЫН БИЕТ ХЭМЖЭЭ 61.2 САЯ ТОННД ХҮРЧ, НИЙТ ЭКСПОРТЫН ОРЛОГЫН 56 ХУВИЙГ БҮРДҮҮЛЛЭЭ.

- Нийт экспорт 9-р сарын байдлаар 11.8 тэрбум ам.доллар, нийт импорт 8.6 тэрбум ам.долларт хүрч худалдааны тэнцэл 3.2 тэрбум ам.долларын ашигтай гарлаа. Нийт экспортын 56 хувийг чулуун нүүрс, 19 хувийг зэсийн баяжмал, 5 хувийг алт, 3.8 хувийг төмрийн хүдэр эзлэж байна. Экспортын өсөлтөд нүүрс, төмрийн хүдрийн биет хэмжээ нэмэгдсэн, мөн дэлхийн зах зээл дээрх алт, зэсийн үнэ өсөж байгаа зэрэг нь эерэг нөлөө үзүүлээ.
- Харин импорт өмнөх оны мөн үеэс 1.9 тэрбум ам.доллараар өсөхөд суудлын автомашин 304 сая ам.доллар, ачааны автомашин 259 сая ам.доллар, дизелийн түлш 187 сая ам.доллараар өссөн нь голчлон нөлөөлөө. Япон улсаас импортоор оруулж байгаа бараа бүтээгдэхүүний 70 гаруй хувийг суудлын автомашин дангаар бүрдүүлж байгаа ба 9 сарын байдлаар суудлын автомашины тоо 93,600-д хүрсэн нь өмнөх онтой харьцуулахад 76 хувиар өссөн үзүүлэлт юм.
- Худалдааны тэнцлийн ашиг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 30 хувиар буюу 1.4 тэрбум ам.доллараар буурсан нь төлбөрийн тэнцэл, ГВАН-д сөргөөр нөлөөлж байна.

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ 8 САРЫН УРЬДЧИЛСАН ГҮЙЦЭТГЭЛЭЭР 187 САЯ АМ ДОЛЛАРЫН АЛДАГДАЛТАЙ ГАРЛАА.

- Төлбөрийн тэнцлийн гол үзүүлэлт болох урсгал данс он гарснаас хойш тасралтгүй алдагдалтай байсан ба 8 сарын байдлаар 832 сая ам.долларт хүрчээ. Урсгал дансны алдагдалд бараа ба үйлчилгээний худалдаа өмнөх оны мөн үеэс 57 хувиар буурсан, мөн анхдагч орлогын дансны алдагдал 1.7 тэрбумт хүрсэн нь голчлон нөлөөлж байна.
- Нөгөө талд санхүүгийн данс 932 тэрбум ам.долларын ашигтай гарч өмнөх оны мөн үеэс 758.6 сая ам.доллараар өссөн байна. Үүнд ГШХО өмнөх жилээс 562 сая ам.доллараар буюу 46 хувиар нэмэгдсэн нь эерэг нөлөөтэй байлаа.
- Төлбөрийн тэнцлийн алдагдал нь гадаад валютын албан нөөц буурахад хүргэж 9 сарын байдлаар ГВАН 4,663 сая ам.долларт хүрлээ.


ХУРААНГУЙ

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	НЭГЖ	ТАЙЛАНТ ХУГАЦАА	ӨМНӨХ ҮЕ	ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕ	ЖИЛИЙН ӨСӨЛТ
УЛИРЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2024Q2	2024Q1	2023Q2	
Бодит ДНБ	тэрбум төгрөг	14,407	6,065	13,631	5.7%
Ажилгүйдлийн түвшин	%	5.76%	5.11%	5.76%	0.0%
Дундаж нэрлэсэн цалин	мянган төгрөг	2,465	2,284	1,890	30.4%
Гадаад өр	сая ам доллар	34,867	35,003	33,790	3.2%
САРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2024M09	2024M08	2023M09	
Гадаад худалдааны үзүүлэлтүүд					
Нийт экспорт	сая ам доллар	11,783	10,686	11,296	4.3%
Зэс	сая ам доллар	2,264	1,971	2,000	13.2%
Нүүрс	сая ам доллар	6,653	6,126	6,418	3.7%
Нийт импорт	сая ам доллар	8,608	-7,502	-6,755	27.4%
Хэрэглээ	сая ам доллар	-2,548	-2,199	-1,922	32.6%
Түүхий эд	сая ам доллар	-713	-635	-627	13.8%
Хөрөнгө оруулалт	сая ам доллар	-3,711	-3,213	-2,828	31.2%
Шатахуун	сая ам доллар	-1,623	-1,444	-1,368	18.6%
Тэнцэл	сая ам доллар	3,174	3,185	4,541	-30.0%
Дэлхийн түүхий эдийн үнэ					
Зэс	\$/тонн	9,259	8,981	8,277	11.9%
Нүүрс	\$/тонн	148.7	151.6	168.5	-11.7%
Газрын тос	\$/баррель	73.1	79	92.7	-21.2%
Алт	\$/трой унц	2,569	2,468	1,915	34.1%
Улсын нэгдсэн төсөв					
Төсвийн тэнцэл	тэрбум төгрөг	2,937	1,371	2,158	36.1%
Төсвийн орлого	тэрбум төгрөг	22,759	18,689	16,908	34.6%
Төсвийн зардал	тэрбум төгрөг	-19,822	-17,318	-14,750	34.4%

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	НЭГЖ	ТАЙЛАНТ ХУГАЦАА	ӨМНӨХ ҮЕ	ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕ	ЖИЛИЙН ӨСӨЛТ
САРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2024M09	2024M08	2023M09	
Мөнгөний бодлого					
М2 нийлүүлэлт	тэрбум төгрөг	41,803	41,565	33,211	25.9%
ХҮИ (C2020)	индекс	146.8	146.7	137.5	6.8%
Бодлогын хүү	%	10.0%	11.0%	13.0%	-23.0%
Хүү ба ханш					
Ам долларын ханш (Эцсийн)	Төгрөг/\$	3,381	3,381	3,460	-2.3%
Төгрөгийн хадгаламж	%	11.5%	11.5%	11.0%	5.0%
Валютын хадгаламж	%	3.9%	3.5%	3.3%	16.7%
Төгрөгийн зээл	%	17.1%	17.0%	16.8%	1.6%
Валютын зээл	%	10.9%	9.5%	10.3%	5.6%
Гадаад валютын нөөц					
Нийт	сая ам доллар	4,663	4,704	4,124	13.1%
Үнэт цаас	сая ам доллар	2,567	1,207	1,859	38.1%
Харилцах, хадгаламж	сая ам доллар	1,409	2,841	1,753	-19.6%
ОУВС-д байршуулсан хөрөнгө	сая ам доллар	7	7	7	3.2%
Зээлжих тусгай эрх	сая ам доллар	96	96	108	-10.5%
Мөнгөжсөн алт	сая ам доллар	583	553	398	46.5%


БОДИТ ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

■ Бодит ДНБ-ий өсөлт (C2015)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

АЖИЛГҮЙДЭЛ БА ЦАЛИН




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ГАДААД ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ




Эх сурвалж: Монголбанк

ДЭЛХИЙН ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ



Эх сурвалж: ОУВС

УЛСЫН ТӨСВИЙН ТЭНЦЭЛ




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

УЛСЫН ГАДААД ӨР




Эх сурвалж: Монголбанк

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ




Эх сурвалж: Монголбанк

УЛСЫН ИНФЛЯЦИ




Эх сурвалж: Монголбанк

ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ




Эх сурвалж: Монголбанк

АМ ДОЛЛАРЫН ХАНШ



Эх сурвалж: Монголбанк

БАНКУУДЫН ДУНДАЖ ХҮҮ



Эх сурвалж: Монголбанк



ЕРӨНХИЙ ЭДИЙН ЗАСАГЧ

Ө. Мөрөн

Цахим хаяг: murun_u@golomtbank.com

ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЭЭЧ

Б. Анунжин

Цахим хаяг: anunjin.ba@golomtbank.com

ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЭЭЧ

О. Номуншүр

Цахим хаяг: nomunshur@golomtbank.com

ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЭЭЧ

С. Цацрал

Цахим хаяг: tsatsral.sa@golomtbank.com

АНХААРУУЛГА

Голомт банкны Эдийн засгийн судалгааны алба нь Монгол улсын макро эдийн засгийг бүхэлд нь хамарч судалдаг билээ. Энэхүү тайлан нь макро эдийн засгийн хамгийн сүүлийн үеийн өгөгдлийг ашигласан болно. Энэхүү тайланд тусгагдсан агуулга, санаа нь Голомт банкны байр суурийг илэрхийлэх албагүй болно. Голомт банкнаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр энэ тайлангийн аль нэг хэсгийг хуулбарлах, системд хадгалах, ямар нэг хэлбэрээр дамжуулах, цахим механик хэлбэрээр хувилах, бичлэг хийхийг хориглоно.